



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/730

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2014 оны “Журам шинэчлэн батлах тухай” 43 дугаар тогтоолын 2.1, 3.3.1, “Аймгийн 2018 оны төсөв батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06/08 дугаар тогтоолын 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суманд 2018 онд байгуулах цэцэг тарих зориулалтын өвлийн хүлэмжийн материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдаж авах, Бат-Өлзий сум дахь сум дундын Ойн ангийн ажиллагсад, байгаль хамгаалагч нарын ажиллах нөхцөлийг сайжруулахад шаардлагатай зардлыг хавсралтаар баталсугай.

2. Арвайхээр суманд байгуулах цэцэг тарих зориулалтын өвлийн хүлэмжийн материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдаж авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Т.Ариунболд)-д даалгасугай.

3. Дээрх үйл ажиллагаанд зарцуулах 36.200.000 (Гучин зургаан сая хоёр зуун мянга) төгрөгийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Т.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА




Г.ГАНБОЛД

011101596

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2018... оны 12.
дугаар сарын ...07. -ны өдрийн 4/1730 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ. Төг	Нийт үнэ мян.төг
1	Цэцэг тарих зориулалтын өвлийн хүлэмжийн материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдаж авах	Мян.төг	1	26400.0	26400.0
2	Сум дундын Ойн ангийн ажиллагсад, байгаль хамгаалагч нарын ажиллах нөхцлийг сайжруулахад шаардлагатай зардал	Мян.төг	1	9800.0	9800.0
	Дүн				36200.0

-оОо-